

НАТУРАЛИЗМ БА ТҮҮНИЙ ХОЁР ГОЛ УРСГАЛЫН ТУХАЙ

Д.Галбаатар¹

Натурализм (*лат. natura, англ. naturalism*) хэмээх гадаад үгийг монголчууд ХХ зууны хоёрдугаар хагасаас судалгаанд хэрэглэх болжээ. Латин хэлний “байгаль”, “оршин буй юм” зэрэг олон утгат үгийг орчин үеийн уран зохиол судлалд уран бүтээлийн арга, урсгал чиглэл гэсэн утгаар хэрэглэж байна.

Натурализм уран зохиол, урлагт эртнээс инагш дэлгэрсэн хэт реалист чиг хандлага бүхий уран бүтээлийн томоохон арга /чиглэл/ юм. ХVIII-XIX зууны сүүлчээр европ, америкийн уран зохиолын практикт эртний сэтгэлгээ ур зүйн туршлагад суурилсан бие даасан чиглэл болон хөгжиж, улмаар онолын салбарт нэвтэрчээ. XIX зууны 70-90-ээд онд өрнө дахин, ялангуяа францын урлаг, уран зохиолын хүрээнд хүчтэй дэлгэрч, анхны цэгцтэй туршилтууд хийгджээ. Энэ нь эрт дээр цагаас урсгалаар хөгжсөн натура урлагийн урлахуй аргын туршлага, сэтгэлгээ хийгээд дүрслэг элементүүдийг ашигласан орчин цагийн уран зохиолын нэг шинэ чиглэлийн үндэс болж хөгжсөн аж.

Натурализмын туурвил зүйн практик үндсийг Э.Золя “*Туршлагын роман*”-аараа тавьж, гүн ухааны үндэслэл нь Э.Геккель, Г.Спенсерийн байгалийн шинжлэлийн материализм, И.Кантын позитивист үзлийг хослуулсан үзэл онолоор баяжиж, амьдралыг өнгөц дүрслэхээс татгалзах үриан дор хөгжсөн түүхтэй.

Натуралист туурвил зүйн үндсэн зарчим өнгөц харвал реализмтай адил төсөө мэт боловч онол, арга зүйн зарчмын хувьд ялгаатай юм. Реализм нийгмийг шинэчлэх, хүнийг орчин ахуй, хөгжил хувьслын явцад нь бодтой үзүүлэхийг зорилго болгодог бол натурализм аж амьдралын хөгжил хөдөлгөөний явц дундын зөрчлийг бус хөдлөшгүй, хувиршгүй байдалд нь мөрдөж тусгах зарчимд суурилсан гул сэтгэхүйн түүхэн зүйг орхигдуулах, урлагийн уран сайхан, уран сэтгэмжийн талыг орхигдуулж, үнэ цэнээ алдах сул талтай.

Натурализм нь романтизмаас ч урт удаан үргэлжилсэн гэж барууны эрдэмтэд үздэг. Натуралист онолын үзэл санааны эхлэл цэг нь В.Шекспирийн зохиолын “*хүнд хүсэл зоригийн эрх чөлөө байхгүй, тэдний хувь заяа төрөлхийн “эмгэнэлт алдаа”-ндаа оршдог*” гэх томъёололд хураагдаж, энэ асуудал уран бүтээлийнх нь үндсэн өгүүлэмж, уран сайхан, илэрхийлэх барил сэдэв санааг тодорхойлдог гэж үздэг байна. Гэхдээ В.Шекспирын зохиолын дүрүүд “*амьдралаас хуулбарлагдаагүй*” тэдгээрт уугуул жишиг /прототип/, “*тогтмол дуудчууд*”-ын дүр байхгүй учраас натуралист бус, мэдээлэгч, тоочигч бус сэтгэгч шинжтэй гэж барууны эрдэмтэд тайлбарладаг. Харин натурализмд хатуу тогтоосон стандарт шаардлага бага,

1. Монгол Улсын Их Сургууль

харин уншигчид руу цоо ширтэгч ямар нэг эмзэг асуудлын процессыг мөрдөх барил ноёрхдог. *Натурализм, романтизм хоёрын гол ялгааг “хашаа түшиж зогсоод амаа чилж, цууртал билүүдэгч”/романтикууд/, “өдөр бүхэн хүнд, уйтгарт хөдөлмөрийн буулган дор амьдралын эрч хүч хадгалагдаж буйг мэдрүүлдэг “бүрээч”/натурализм/ бүтээлч хэв шинжтэй болохыг А.Розенбаум нэлээд оновчтой тодорхойлжээ.*

Натурализмыг урлаг, уран зохиолын амь болсон уран сайхан, түүний үүрэг, нөлөөг дутуу үнэлэх, амьдралын үзэгдэл явдлыг буй байдалд нь мөрдөх, өнгөц зурах, тоочих, хүн өөрийн аж төрж буй нийгмийн орчин ахуйд баригдмал болох, эргээд тэрхүү орчин ахуйдаа нөлөөлөх талыг бага анхаардаг сул талтай гэж бусад урсгал чиглэлийнхэн шүүмжилдэг. Тэд амьдралын мөнх оршихуйн учир ёсыг нотлохыг эрмэлздэг ч, хүний биологийн болон байгалийн хүчин зүйлийг хэт үнэлэх, хүний сайн сайхны хүсэл эрмэлзлэгт бага анхаарч зовлон зүдгүүр дуусашгүй гэх гутранги үзэл санаанд баригдах шинжүүд нь зохиол бүтээлийг нь ерөнхийдөө уйтгарт бараан өнгө аястай болгодог. Гэхдээ олон ургальч үзлийн үүднээс амьдралыг мөрдөж, нарийн дүрслэх эрмэлзлэг, байр суурийг үгүйсгэх аргагүй юм. Натурализм эргний сурвалжит хүчтэй аргын нэг мөн. Монголын эрт ба эдүгээгийн уран зохиолд ч натурализм өөийн жамаар хөгжиж ирсэн билээ.

Натурализм нь биологизм, фотографизмын хоёр гол урсгалыг нэгдэл юм. Түүний бичлэгийн арга зарчим, сэтгэлгээний хэв маяг, хөгжсөн түүхийн улбаа мөр монголын эртний ба орчин үеийн уран зохиолын хөгжлийн эхэн үеээр нэлээд хүчтэй дэлгэрч байжээ. Хуульч Сандаг, ерөөлч Гэлэгбалсангийн уран бүтээл ба Д.Чимэдийн *“Янагийн үнсэлт”*, М.Ядамсүрэнгийн *“Гурван хүүхэн”*, *“Замаа алдсан Жамъянмядаг”*, Ши. Аюушийн *“Марал, Шарын жүжиг”* зэрэг тухайн цаг үедээ шүүмжлэгдэж асан цөөнгүй зохиолын бичлэг сэтгэлгээнд биологизм, М.Ядамсүрэнгийн *“Залуу хос”*, Ц.Дамдинсүрэнгийн *“Гологдсон хүүхэн”*, Д.Чимэдийн *“Хар харгисын ярицаан”*, *“Худалч хүний хооролдоон”*, *“Баячууд баяргүй үгс хэлэлцэнэ”*, С.Бүянийэмэхийн *“Шөнийн бүг”*; *“Өвлийн доторх ядуу гэр”*; *“Хадны дээрх галий хоньчин”* зэрэг бүтээлд фотографик бичлэгийн барил тод юм.

Энэ аргын талаар зохиогчийн “Монголын уран зохиолын аргын судалгаа” докторын диссертациас дэлгэрүүлэн үзэж болно. УННС, УБ, 1999/

ФОТОГРАФИЗМ (*анг. photographism*) монгол уран зохиолын бүтээгч язгуур аргын нэг төдийгүй натуралист чиглэлийн бие даасан урсгал юм.

Фотографик арга нь урлаг, уран зохиолд байгаль, нийгэм, хүний аж төрлийг дүрслэхдээ гадаад дүрийн илэрхийлэл, шинж тэмдэг, өрнөлийн процесс буюу үйлдлүүдийг ягштал мөрдөх, тоочих маягаар үзэгдэл, юмсын дотоод учир шалтгаан, гоо сайхан, язгуур мөн чанарыг нээх эрэлхийлэл голлодог арга юм. Монголын орчин үеийн уран зохиолд натуралист барил 1920-30-аад онд мэдэгдэхүйц дэлгэрсэн төдийгүй гэдгээрт натурализмын фотографик дүрслэлийн хэв маяг илт ялгардаг.

Монголын шинэ үеийн уран зохиолын төлөөлөгч М.Ядамсүрэнгийн бүтээлд натуралист хандлага бийг үндэсний судлагчид тэмдэглэжээ. Ялангуяа *“Залуу хос”* туужийг ийм хэв шинж бүхий хэмээн элдэвлэн шүүмжилж асны учир шалтгаан нь гол баатар Жанцангийн дүр, амьдралын нэгэн мөчлөг үеийн орчин, нөхцөл байдлыг урласан арга барилтай холбоотой юм.

Тухайлбал: Ганц бие залуу эрийн арчаагүй наазгайг түүний гэрийн доторх *“...Хаалгыг тайлж дотогш орвоос цөм өглөөний хэв, мөнөөх янз, сугарч боссон хөнжил нь орны дунд бөөгнөлдөн, базсан цаас, папиросын шилбэ энд тэнд үзэгдэх эх захгүй, дээл гутал тасалгааны энэ тэр өнцөг буланд хөглөрөөд орны дээд, доод хөндийд хиртэй цамцыг хэд хэдээр хүмхин чихэж дутуу хаасан цонхны хаалга, байшингийн доторхийг гэрэлтүүлэн хагас шаазан цай ширээн дээр үлдсэний дотор хоёр ялаа унаж үхсэн агаад...эргэн тойрон нэг хэв, мөнөөх янз нэг ч хөдөлгөөнгүй, нэг ч сонирхолгүй, чив чимээгүй, нам гүмийн дотор Жанцан ганцаар*

эргэлдэн байжээ. Өмнөх сандлын онцөг дээр түр суух зуур ширээн дээрх шаазантай цайны үлдэгдлийг цонхоор асгаж бэлэн байсан данхтай хүйтэн цайнаас нэг аяга цай залгилаад чимээгүй гүний дунд уйтгарлан сууж нэгэн зэрэг сэтгэлтэйгээ ярилцан, ядарсан бие амрах дургүй, бичгийн савыг ширээн дээр тавьж дугуйгаа түлхэн гаргаад хадгалан хүлээгч хар цоожиндоо хаалгыг тушаан баруун зүг одов" / "Түүвэр зохиол". 15-р тал/ зэргээр дүрсэлж, арчаагүй хайнга байдлыг гэрийн доторх зүйлсийн зураглалаар нэг бүрчлэн бүртгэн тоочих аргаар илэрхийлжээ. Баатрын хайш яайшхан үйлдэл, гэрийн эмх цэгцгүй байдлын хослолууд, илүүц гэмээр юухан хээхнийг ч болов орхигдуулахгүйг хичээх бичлэгийн энэ хэлбэрийг фотографууд өргөн ашигладаг. Дээрх зохиолын цаашдын өрнөл ч бүхэлдээ ийнхүү мөрдөх, бүртгэх аргаар баялаг юм.

Зохиолын эхэнд "...алба тармагц морьтой, явган, дугуйтай, машинтай, эрэгтэй, эмэгтэй олон хүмүүс бужигналдаж, гэр гэрээдээ ирж хувцас хунарыг тайлан, хөл гарыг дэлгэн их тавтайгаар идээ ундааныг идэж, шинэ хүчийг залгах ажээ." зэрэг процессыг угсруулсан илэрхийлэл нь олон мэдээллийг агуулаад зогсохгүй, олон өвөрмөц хөдөлгөөн ба дүр зургийг илэрхийлсэн сайн талтай ч ур чадвар, уран сэтгэмж, сэтгэл зүйн эрэл, дүрийн дотоод ертөнцийг нээх тал дутмаг байгаа нь фотографик аргын сул тал төдийгүй түүний оршихуйн бодот мөн чанар нь юм.

Гэрэл зураг мэт дүрслэл зарим судлаачдын үзэхээр ганц нэг бүлэгт тааралдах бус туужийн бүх хэсэгт гархмал юм. Тухайлбал гэрээс гарсан Жанцан Монгол банкны гудамж дахь хоолны газрыг зорьж, орсон ба нэгэн залуу бүсгүйг онцолж харсан, түүний гадаад төрх, байр байдал, намба, зан ааль, нүүр царай, хувцас зүүсгэл, ганц бие Жанцангийн мөрөөдөл, дур хүслэн, гуанзнаа хооллох хүмүүсийн байдал, дуу шуугиан бүхнийг тоочиж, эцэст залуу охиныг сэм даган гараад тэргэнд хамт сууснаар танилцсан... бүх хэсэгт фотографикийн дүрслэл ноёрхдог.

Өрнөдийн судлаачид "романтик зохиолуудад өргөн ашигладаг натуралист хэв загвар нь натурализмын холимог хэлбэр болох "романтик-натурализм" хоёрын гоо зүйн тайлбар нэг байж болох, мөн туурвил зүйн ижил зарчим гэдэг асуудлыг тавих боломж олгож байна" /Миловидов.В.А. "Натурализм: метод, поэтика, стиль" Тверь. 1993. 23, Dobbg.B, Dobbg. J. 181/ гэжээ. Уран бүтээлийн арга барилууд дангаар оршихоос гадна нэгэн бүтээлд нэгдэн нийлэгшсэн байж болохыг ориенталистууд тэмдэглэжээ. Ц.Дамдинсүрэн "Гологдсон хүүхэн" /1929/, Д.Цэвэгмидийн "Хоньчин Найдан", "Болд Самбуу хоёр" зэрэг 1930-аад оны туужуудад иймэрхүү бичлэг, сэтгэлгээний хэв маяг бий. Сонирхолтой нэг тал нь натурализмтай ямагт нөхцөлддөг сентименталь хандлага, романтик тэмүүлэл эдгээр бүтээлд мөн ажиглагддаг.

БИОЛОГИЗМ (анг. *biologism*) Натурализмын дотоод урсгал. Натуралист уран бүтээлийн аргын гоо сайхны нэг үндсэн зарчим нь хүний хувийн амьдрал, бэлгийн харилцаа, биологийн төрмөл шинжүүдийг ил задгай, байгалийн хүчин зүйлийн түвшинд нь ойртуулж дүрслэх зарчим юм. Бэлгийн харилцааны асуудал нь уран зохиолын нэг гол сэдэв, өгүүлэмж байсаар ирсэн бөгөөд уран сайхны янз бүрийн орчинд, янз бүрийн зорилго, үзэл, зарчмаар дүрслэгдэж иржээ. Түүний нэг хэлбэр нь хүний биологийн сонирхлын хүчин зүйлс рүү хандсан биологизм байв.

Энэ мэт биологийн хүчин зүйлсийн өгүүлэмжийг фотограф аргаар илэрхийлэхэд уншигч үзэгчдийн сонирхлыг өдөөх, татах хүч эрчимтэй бус учраас хүний амьдралын гол чухал хэрэгцээний нэг болох бэлгийн амьдрал, эротик /тачаангуй/ хандлагыг илүү шохоорхох байдал нийгэмд бий болж тэдний эрэл, зохиол туурвилын нэг талыг чухалчилдаг биологизмыг төрүүлжээ. Энэ урсгал хэдийгээр Европт дэлгэрсэн гэх хэдий ч дорны урлагт түүнээс ч эрт хөгжсөн билээ.

Монголын эрт, эдүгээгийн уран зохиолд биологизмын арга барил нэлээд дэлгэрсэн

төдийгүй гадаадын уран зохиолын орчуулга, тухайлбал Хятадын “*Алтан бумбан дахь лишийн цэцэг*”, 1920-30-аад оны монгол бичгийн уран зохиол, түүний дараа үед ч үзэл суртлын хяналтаас болгоомжлон нууцаар бичиж, амаар дэлгэрч байсан эр эмийн бэлгийн харилцааны явдлыг өгүүлсэн зохиолууд олон бий. Нэг жишээ нь М.Ядамсүрэнгийн “*Гурван хүүхэн*” тууж, “*Замаа алдсан Жамъянмядаг*” найраглал, Д.Чимидийн “*Янагийн үнсэлт*” бичил хүүрнэмж, Ши.Аюушийн “*Марал, Шарын жүжиг*”-т ийм шинж тэмдэгүүд буй.

Судлаачид хүний биологийн эрэлт, хэрэгцээ, сонирхлын үндэс нь бэлгийн харилцаанаас үүтгэлтэй гэж үзэх ба тэрхүү далд нууцлаг үйлдэх үйлийг уран зохиолд харуулах, тусгах хэрэгцээ натурализмын дүрслэх арга зарчмын дотоод хүчин зүйлсээс эх сурвалжтай юм. Фотографизм нь уран сайхны амт шимт, сонирхол татах шидээр дутмаг сул тул тэрхүү мухардлаас гарах эрэл хайгуулын үрээр хүний физиологийн асуудлыг сонирхуулан бичих хэрэгцээ бий болсноор биологизм салбарлан хөгжжээ.

Биологизмын “*гүн ухааны үндэс нь И.Кантын позитивизм бөгөөд гоо зүйн онолын суурь нь И.Тэний сургаалтай холбоотой*” /*Авессаломов, Г.С Натурализм. 1988.237*/ тул хөрөнгөтний нийгэм рүү шилжих эхэн үед зугаа цэнгээний /хэрэглээний/ урлагийн хэлбэрээр үүссэн гэжээ.

Ш.Гаадамба “*хөрөнгөтний уран зохиолд хүний аж амьдралын чухал асуудал үнэнч ариун янаг хайрын сэтгэлийн оронд хүний биологийн /адгуусны/ сэрэл, хуял тачаалыг махбодчлон дүрслэх “үжид самууны роман” дэлгэрсэн нь ийм натуралист хэв төлөвийн аргын дүрслэл байдаг*” /*Ш.Гаадамба. “Уран зохиолын онолын үндэс. 1987. 236-р тал*/ гэжээ. Үүнээс үзэхүл өрнө дахинаа “*вещизм*” буюу “*юмшууллын урсгал*” гэж нэрлэдэг биологийн үйлдэл /идэх уух, унтах хурьцах, тачаах, залхаг ахуйн дундах хүний биологийн үйл гэх мэт/ урлагт ил задгай өгүүлэх уран зохиолын урсгал монголчуудад эртнээс байж. Үүний жишээ нь хуульч Сандагийн “*Эцээд хэвтэж байгаа ухны хэлсэн нь*”, “*Шинэ азарган үрээний хэлсэн нь*”, “*Ороод хоцорсон буурын хэлсэн нь*” зэрэг мал ахуйн ороо отооны явдлыг ил тод өгүүлсэн зохиолууд илтгэнэ.

Хувьсгалын эхэн үеийн уран зохиолд /*үргэлжилсэн уг, жүжиг*/ ч биологизм хурц илэрч байв. Жишээ нь: Д.Чимид “*Янагийн үнсэлт*” өгүүллэгтээ санамсаргүй байдлаар тохиолдоод дур хүсэлдээ хөтлөгдөн ухаан мэдрэлгүй, зууралдан мансуурч буй залуу хосын будангуйшлыг махбодчлон, үйлдэл ба үйлийн улам гүнзгийрч даамжрах байдлаар залгуулан өгүүлснээс ухамсар, ахуй, оюун ухааны зохицуулалтаас огт оор цэвэр амьтны физиологийн рефлекс чанарын үүднээс харуулсан нь биологизмын гол шинж болох “*хүний урамсаргүй үйл ажиллагаанд голлон тулгуурлаж, биологийн зөн билиг, мэдрэмж, рефлекс гол үүрэгтэй байдаг*” /*Истории Французской литературы. М.1959. 100*/ онцгой шинжүүд уг бичил эхэл тодорхой илэрдэг.

“*Марал, Шарын жүжиг*”-т хүний бэлгийн харилцааны гаж зуршил болох /үл ухамсарлахуй/ хүчирхийллийн дүрслэл, М.Ядамсүрэн “*Гурван хүүхэн*” туужийн Ү бүлэгт бие үнэлэгч Занданбал нутгийн хүний хувьд зочлон ирсэн цэвэр, онгон Хас-Эрдэнэ бүсгүйг хуял тачаалын ертөнц рүү татан оруулахын тулд “*Чи өнөөдөр их л ичиж байна. Маргааш том толнины өмнө нүцгэн наадахдаа бахтай сайхан...*”, “*Занданбал шарваганан босч ирээд нэгэн хятадын өвөр дээр үсрэн сууж биеийг гэдрэг эргэн хоёр гарыг сунгаж, хятадын хүзүүгээр чанга тэврэн, татаж бөхийлгөөд хошууг нийлүүлэн хэлийг шимэлцэнэ.*”, “*Занданбалд согтсон учрыг хэлбэл тэр Хас-Эрдэнийг хөтөлж аваачин нэг орны дээр хэвтүүлж, битүү цагаан хөшгийг буулгав...* Занданбал Хас-Эрдэнийн согтсоныг бодохгүй тэдгээр иргэд лүгээ үнэ хэлэлцэн битүү цагаан хөшигний дотор ээлжээр оруулна” Тийнхүү хэдэн цагийн завсар “*хэд хэдэн хятад*” ээлжлэн мөн “*Занданбал өөрөө өндөр толнины өмнө нүцгэнээр загас наадуулах арван гурван зүйлийн явдлыг үзүүлнэ...* Залуу хятадуудын сэтгэл ханаж гэр гэртээ буцсанд морьтын хишиг явганд хэмээх үлгэрээр чадал тамир доройтсон боловч

хүсэл санаа хүлцэшгүй шунахай хоёр хөгшин хятад үлдэж... нэжгээдээр өвөрлөн хэвтэв”, “Хас-Эрдэнэд одор шөнийн хорин дөрвөн цагт залуу, хөгшин зочид лугаа цэнгэлдэн умард хаалгаар хуучныг гаргаад, өмнөд хаалгаар шинийг угтаж оруулан... нэгэн цагаан тохойг түмэн хүнд дэрлүүлэн, нимгэн улаан уруулыг мянган хүнд үнсүүлж, хөөрхөн зелдэг биеэ хөтөвч сав” /Түүвэр зохиол. 63-66/ мэт болж буй үйлдэл, байдлыг угсруулан залгаж бичжээ.

1990-ээд оноос инагш бичлэгийн энэ уламжлал сэргэж, дээрх дүрслэлээс ч илүү махбодчлон илт үзүүлэх, үйлдэх, бичих явдал ихэссэн нь нийгмийн хямрал, бичиж зохиох хувь хүний эрх чөлөө, нийгмийн задрал, ардчилах үйл явцтай олон талаараа холбоотойн дээр өрнийн “нийтийн соёл”, “масс”-ын уран зохиол, тэр дундаа порнобизнес /арилжааны уран зохиол/ монгол уран зохиолд түрэмгийлэн орж ирж буйн дохио тэмдэг юм. Залуу зохиолч “Сексийн хаанчлал” /Ш.Билигсайхан/ цуврал роман бичжээ.

Биологизмын зарчим зүйг уран бүтээлд ашиглах боломж нээлттэй боловч ёс зүйн хэм хэмжээний хил хязгаарыг давбал садар самууны сурталчилгаа болох аюултай. Бэлгийн харилцааны сонирхол хүн бүхэнд заяамал боловч түүнд хандах хандлагаар хүний язгуур мөн чанар тодорхойлогддог тухай үзэл биологизмын урсгалыг баригчдын зохиолын үндэслэл болсон нь психоанализын онол, суралгааны үр дүнтэй ямар нэг талаараа холбогдох билээ.

З.Фрейдийн “Зүүдний тайлал”, “Сүлд шүтлэг ба хорио цээр”, “Хүний бэлгийн амьдралын тухай” /XX лекц/ бүтээлүүд XX зууны энэ урсгалын онолын сүүл үеийн чиг баримжаалал болдог. З.Фрейд “Эдин хаан” жүжгийн дүрийн сэтгэцийн судалгаандаа бэлгийн харилцааны үндсийг хувь бодгалийн ухамсаргүй үүднээс тайлбарласан бол түүний шавь К.Юнг нийтийн ухамсаргүйн онолдоо урьд эртийн мэдээллүүд хойчийн хүмүүст ухамсаргүйгээр уламжлагдан хадгалагдаж байдаг зүй тогтлыг “архетип” хэмээн төмьёолсон билээ.

Өнөөгийн сексийн болон порнограф зохиолоос гадна уран зохиолын бүх төрөл зүйлд биологийн хүчин зүйлс ба бэлгийн харилцааны дүрслэлүүдийг ямар нэг хэмжээгээр ашиглаж, бүр тийм өгүүлэмжтэй бүрэн хэмжээний роман туужис, жүжиг бичигдэж олон нийтийн анхаарлыг татсаар байгаа нь орчин цагийн уран зохиол дахь биологизмын шинэ чиг хандлагын илрэлүүд хэмээн үзэж болох билээ.

Иймд натурализмын гол хоёр урсгал болох фотографик хийгээд биологизмын урсгалууд түүхэн нэг цаг үед байгаад өнгөрсөн хуучин урсгал төдий бус өдгөө ч амьд буй уран сайхны өвөрмөц арга гэж үзэх учиртай болж байна.

SUMMARY

The ancient and modern literature of Mongolia has created many different genres, akin to the famous literary pieces that have spawned across the globe. One of these genres is Naturalism, which is an important feature of Mongolia literature.